

Техникийн тодорхойлолт

Ажиллагсад олгох хүнсний нэмэлт бүтээгдэхүүн

Ерөнхий шаардлага:

1. Бүтээгдэхүүний орц найрлагад цэвэр жимс, жимсгэний шүүс эсхүл сүү сүүн бүтээгдэхүүн орсон байна.
2. Нэгж бүтээгдэхүүн нь шууд ууж хэрэглэх боломжтой 100мл-с багагүй хэмжээгээр савласан шингэн шахмал эсхүл шууд найруулж уух боломжтой нунтаг хэлбэрийн байна.
3. Бүтээгдэхүүн нь хөдөлмөрийн хортой нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэдэг ажилтнуудын биед хуримтлагдсан хүнд химийн элементийг саармагжуулах, гадагшлуулах Бие махбодын дархлааг тэтгэж биеийн эсэргүүцэл сайжруулах, ядаргаа тайлж ажлын эрч хүчийг нэмэгдүүлэх үйлчилгээтэй байгалийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн байна.
4. Санал болгож буй бүтээгдэхүүний сав, баглаа боодол нь хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол, техникийн ерөнхий шаардлага MNS 5547:2005 стандартын шаардлага хангасан байна.
5. Санал болгож буй хүнсний бүтээгдэхүүн нь нэг ширхэг бүрээр тусдаа савалсан савалгаатай байна.
6. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалын хавсралтад заасны дагуу хүний хоногт хоол хүнсээр авбал зохих хэмжээ А, Д, Е, К, С, В1, В2, В6, Ниацин В3, Биотин, В5, В12 зэрэг амин дэмүүд болон Фолийн хүчил Кальци, Селен, Магни, Цайр, Төмөр, Фосфор, Иод, Кали, Фтор, Манган, Молибден, Хром, Натр зэрэг эрдэс бодисууд, үл орлогдох амин хүчил тус бүрээс тодорхой зохист хэмжээгээр агуулсан байна.
7. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах хүнд элемент, хор судлал болон нян судлал зэрэг нь эрүүл ахуйн шаардлага хангасан тухай итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнг ирүүлнэ.
8. Түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлсон мэргэжлийн лабораторийн шинжилгээний дүн, баримт материалыг ирүүлнэ.
9. Дээрх шаардлагыг хангасан 2 өөр нэр төрлийн бүтээгдэхүүн санал болгож болно.

Тусгай шаардлага:

1. Хүнсний бүтээгдэхүүн нь хэрэглэж буй ажилтны өдөр тутмын хоол хүнс болон эм эмчилгээний үед, харшлах орц найрлагагүй, аливаа хориглох заалтгүй байна.
2. Хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын хөргүүртэй, битүүмжлэлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэн хүргэнэ.
3. Хүнсний бүтээгдэхүүнийг зөөж тээвэрлэх тээврийн хэрэгслийн гэрчилгээ, фото зураг бүхий мэдээллийг ирүүлнэ.
4. Бүтээгдэхүүн нь битүүмжлэгдсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан гадны нөлөө орохгүй савалгаатай, үйлдвэрлэсэн хугацаа, хэрэглэх заавар, харшлах зүйлс болон найрлагыг тодорхой бичсэн байна.
5. Санал болгож буй хүнсний бүтээгдэхүүний дээж болон танилцуулгыг ирүүлнэ.

6. Нийлүүлсэн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол нь задарсан, урагдсан, нарны хэт туяаны нөлөөнд орсон, хөлдсөн, зориулалтын бус тээврийн хэрэгслээр ил задгай тээвэрлэсэн тохиолдолд барааг хүлээн авахгүй бөгөөд ашиглах боломжгүй барааг буцаана.
7. Хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй /норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн зэрэг/ бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд үл маргах журмаар хэрэглэгчийг хохиролгүй болгоно.

Бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хуваарь, тоо ширхэг

№	Бүтээгдэхүүний нэр	2024 он	2025 он	Нийт
		IV улирал	I улирал	
1	Байгалийн гаралтай хүнсний нэмэлт бүтээгдэхүүн	14787 ш	44362 ш	59149 ш
Нийт				